**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр Дугаар А/402 Улаанбаатар хот

Өнөр бүл хүүхдийн төвийн данс
бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 1 930 000 /нэг сая есөн зуун гучин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 2 тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Өнөр бүл хүүхдийн төв /М.Өлзийчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Өнөр бүл хүүхдийн төв / М.Өлзийчимэг /-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

1119202405 ЦШ.2576589

11505000114

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн
А/402 дугаар тушаалын хавсралт

1119282495 ш. 2576589

СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ ХУДАЛДАХААР ШИЙДВЭРЛЭГДСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД

/төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Марк, дугаар | Үйлдвэрлэг-дсэн он | Баланс үнэ | Байгуулсан элэгдэл | үлдэгдэл үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өнөр бүл хүүхдийн төв | FT-200 бага оврын трактор | 1995/2006 | 30,000 | 30,000 | - |
| 2 | | FT-200 бага оврын трактор | 2006/2006 | 1,900,000 | 1,900,000 | - |
| | | | | **1.930.000** | **1.930.000** | **0** |